



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 22-дээр

Дугаар 4725

Арвайхээр

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний албанд ирүүлэхийг сумын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3. Тухайн жилийн агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоо бүртгэлийг нэгтгэх, Арвайхээр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд хэмжилт судалгаа хийж ажиллахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга (Б.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

4. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн ажлын үр дүн, санал, дүгнэлтийг жил бүрийн 05 дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсэг ахлагч (С.Ундрах)-д үүрэг болгосугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарны 25-ны өдрийн а/546 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100062

Аймгийн Засаг даргын 2021 оны...01...  
дугаар сарын ...-ны өдрийн .....дүгээр  
захирамжийн хавсралт

АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭРИЙН НЭГДСЭН  
ТОО БҮРТГЭЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн  
Газар, байгаль орчин, аялал жуулчлалын бодлого  
төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд: -Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга

- Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны Орчны шинжилгээний ерөнхий технологич, инженер
- Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны Байгаль орчны шинжилгээний лабораторын эрхлэгч
- аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Орчны бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн
- Авто тээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер
- Сумын Засаг дарга нар
- Сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байцаагч, байгаль хамгаалагч

-оOo-